



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/83

Ховд

「Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай」

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 2.21 дэх заалт Худаг гаргах /Чандмань сум/ 25,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Чандмань сумын Засаг дарга /З.Онолбаатар/-д шилжүүлсүгэй.


2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг үндэслэлтэй боловсруулж 03 дугаар сарын 25-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсаны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 08 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг Чандмань сумын Засаг дарга /З.Онолбаатар/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавихыг Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

